

Creative Commons – дэлхий дахинтай бүтээлээ амархан хуваалцах нь

Бүтээлээ тараан түгээх 6 лиценз

Интернет хэн бүхэнд хийсэн бүтээснээ бусадтай хуваалцах, цааш хөгжүүлэх хялбар боломжийг бүрдүүлж өгсөн. Гэвч заримдаа хууль, эрх зүйн орчин энэ бүхэнд хүндрэл учруулдаг.

Өөрийн авсан фото зураг, дуу бичлэг, нийтлэл болон бусад бүтээлээ интернетэд тавих бүрт зохиогчийн эрхийн хуулийн дагуу автоматаар “бүх эрхээ хамгаалуулах” хэрэгтэй болдог.

Ихэнх тохиолдолд энэ нь бусад хүмүүс эхэлж таниас зөвшөөрөл авалгүйгээр таны бүтээлийг өөрчлөн хөгжүүлж дахин ашиглах боломжийг хаадаг.

Хэрэв та өөрөө бусад хүмүүсийг бүтээлийг тань өөрчлөн хөгжүүлж ашиглаасай гэж **хүсэж** байвал яах вэ?

Хэрэв таны бүтээлийг хүмүүс цааш нь түгээх тараах, хэрэглэх, өөрчлөн хөгжүүлээсэй гэж хүсэж байвал Creative Commons (Бүтээлч хамтын өмч) лицензийг ашиглахыг зөвлөж байна.

СС лиценз нь ямар эрхийг өөртөө хадгалж үлдээх, бусад хүмүүс таниас асуухгүйгээр бүтээлийг тань хэрхэн ашиглаж болохыг тодорхой тайлбарлаж өгсөн байдаг.

1-р алхам: Лицензээ сонгох

Creative Commons лицензийг бүтээлдээ ашиглах амархан. Эхэлж та өөрийн бүтээлээ ямар нөхцөлөөр ашиглахыг зааж өгнө.

Нэрийг заах

Бүх төрлийн СС лицензийн дагуу таны бүтээлийг ашиглаж буй хэн бүхэн таны нэрийг дурьдах үүрэг хүлээдэг. Хэрэв таны нэрийг дурьдахыг хүсэхгүй тохиолдолд эхэлж таниас зөвшөөрөл авах хэрэгтэй.

Ашгийн бус

Та бусдад таны бүтээлийг ашиг олох зорилгоор биш бол хуулбарлах, түгээн тараах, өөрчлөх (NoDerivs-г сонгоогүй тохиолдолд), бусад ямар нэгэн хэлбэрээр хэрэглэх эрхийг олгоно. Хэрэв ашиг олох зорилго агуулвал эхэлж танаас зөвшөөрөл авна.

Ижил нөхцөлөөр цааш дамжуулах

Та бусдад таны бүтээлийг хуулбарлах, түгээн тараах, өөрчлөх эрхийг ижил нөхцөлөөр цааш дамжуулах эрхийг олгоно. Хэрэв өөрчилсөн бүтээлийг өөр нөхцөлөөр цааш дамжуулах бол таниас зөвшөөрөл авна.

Боловсруулахгүй

Та бусдад зөвхөн анхны эх бүтээлийг л хуулбарлах, түгээн тараах, үзүүлэх эрхийг олгоно. Хэрэв таны бүтээлийг өөрчлөх бол таниас зөвшөөрөл авах ёстой.

2-р алхам: Лицензээ авах

Та хийсэн сонголтынхоо дагуу бусад хүмүүс таны бүтээлийг хэрхэн ашиглаж болохыг тодорхой заасан лицензийг авна.

Бидний **үнэ төлбөргүй, ашиглахад хялбар** лицензүүд таны бүтээлийг олон нийт ашиглах стандарчлагдсан зөвшөөрлийг олгодог. СС лицензүүд таньд зохиогчийн эрхийн “бүх эрхийг хамгаалагдсан” хэлбэрээс “зарим эрх хамгаалагдсан” хэлбэрт шилжих боломжийг хялбархан олгоно.

Creative Commons бол зохиогчийн эрхийг орлох хувилбар биш юм. Анх өгөгдсөн хэлбэрээр бол зохиогчийн эрх нь дахин ашиглах боломжийг маш хязгаарлагдмал байдлаар л олгодог. СС лиценз таньд өөрийнхөө зарим эрхийг авч үлдэхийн хажуугаар таны шаардлагад нийцсэн хэлбэрээр бүтээлийг тань ашиглах нэмэлт боломжийг олон нийтэд олгодог.

Бид дэлхийн аль ч улсад манай лицензийг ашиглах боломжийг бий болгохын тулд олон орны оюуны өмчийн мэргэжилтэнүүдтэй хамтран ажилладаг.

Хэрэв та хууль ёсны дагуу, үнэ төлбөргүйгээр ямар нэг бүтээлийг ашиглахыг хүсвэл СС лиценз авсан хэдэн зуун сая дуу, видео, сургалтын материал зэрэг олон тооны бүтээл туурвил бий. Энэ бүхэн цаашид ч өдөр бүр өсөн нэмэгдэж байна.

Creative Commons гэж юу вэ?

Creative Commons бол интернетэд суурилсан үнэ төлбөргүй мэдлэг, туурвил бүтээлийг хүмүүст нээлттэй, хүртээмжтэй хэлбэрээр хэрэглэх, түгээх, хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилго бүхий олон улсын ашгийн төлөө бус байгууллага юм.

Бидний үнэ төлбөргүй, ашиглахад хялбар лицензүүд таны бүтээлийг олон нийт ашиглах стандарчлагдсан зөвшөөрлийг олгодог. СС лицензүүд танд зохиогчийн эрхийн “бүх эрхийг хамгаалагдсан” хэлбэрээс “зарим эрх хамгаалагдсан” хэлбэрт шилжих боломжийг хялбархан олгоно.

СС лицензийг дэлхийд хамгийн өргөн хэрэглэгддэг сайтууд дээр сая сая хүмүүс өөрсдийн бүтээлийг тавихад ашигладаг. СС лиценз авсан таны фото зураг, видео, блог зэрэг нь бусад зураач, багш, эрдэмтэд болон төр, засгийн газруудын бий болгосон дэлхий дахинд нээлттэй бүтээл, нөөц эх үүсвэрийн сангийн нэг хэсэг болдог.

Creative Commons энэхүү гарын авлагыг ССО буюу нийтийн өмч гэж үзэн бүхий л зохиогчийн эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн хязгаарлалтаас чөлөөлсөн болно.